

Аргачлалын тайлбар :

ОРОН НУТГИЙН ТӨСӨВ

Төсвийн орлого, зарлагын тооцоог Олон Улсын Валютын Сангийн стандарт ангиллаар 1995 оны 10-р сараас эхлэн гаргаж байна. Төсвийн орлогын мэдээг аймгийн Татварын хэлтэс, төсвийн зарлага, санхүүжилтийн мэдээг СЭЗТС-ийн хэлтсээс гаргадаг.

Төсвийн орлогын мэдээг хэрэглэгчдэд илүү тодорхой болгох зорилгоор аймгийн нийт төсвийн орлого, үүнээс улсын төвлөрсөн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөөний биелэлт, орон нутгийн төсөвт (аймгийн) төвлөрүүлэх орлогын төлөвлөгөөний биелэлт гэж салгаж харууллаа.

Төсвийн зарлагыг эдийн засгийн салбарын ангиллаар гаргаж, улсын төсвийн байгууллагууд, орон нутгийн төсвийн байгууллагууд гэж тус тусдаа гарсныг нэгтгэж орууллаа.

ҮНЭ

Аймгийн төвийн хүнсний зах дээр борлогдож байгаа хөдөө аж ахуйн гаралтай хүнсний бүтээгдхүүн, ноос, ноолуур, арьс шир зэрэг зарим бүтээгдхүүний зах зээлийн дундаж үнийг харуулав.

Хэрэглээний үнийн индекс гэдэг нь өрх орлогоороо өөрсдийн хэрэгцээнд худалдан авсан, үйлчлүүлсэн хамгийн чухал, эн тэргүүний нийтлэг хэрэгцээтэй бараа, үйлчилгээний үнийн өөрчлөлтийг тэдгээрийн хэрэглээний зардалд эзлэх хувиар жигнэсэн дундаж юм.

2006 оноос эхлэн хэрэглээний сагсны нэр төрлийг шинэчилж 194 нэр төрөл болгож 2005 оны 12-р сарын үнээр суурилан ХҮИ-ийг тооцож байна.

АЖ ҮЙЛДВЭР

Аж ахуйн нэгжүүдийг эдийн засгийн үйл ажиллагаар нь ангилахдаа НҮБ-ийн эдийн засгийн үйл ажиллагааны Олон улсын стандарт ангиллыг мөрдөж байна.

Аж үйлдвэрийн борлуулсан бүтээгдхүүн нь аж ахуйн нэгж, байгууллагын тайлангийн хугацаанд худалдсан буюу гадагш гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний хэмжээ юм.

Аж үйлдвэрийн нийт бүтээгдхүүний өсөлтийг гол нэр төрлийн бүтээгдхүүнийг 2000 оны зэрэгцүүлэх үнээр үнэлж тодорхойлсон болно.

Гол нэр төрлийн бүтээгдхүүний үйлдвэрлэл нь тухайн бүтээгдхүүний үйлдвэрлэлийн биет хэмжээг харуулна.

ХӨДӨЛМӨР

Ажилгүйчүүдийн тоонд олон улсын стандарт ангиллын дагуу Монгол улсын хуулиар зөвшөөрөгдсөн хөдөлмөрлөх насны, хөдөлмөр эрхлэх чадвартай, цалин хөлстэй ажил болон хувиараа хөдөлмөр эрхэлдэггүй, тухайн үед ажиллахад бэлэн, цалин хөлстэй ажил идэвхитэй эрж, хайж байгаа хөдөлмөр эрхлэлтийн албанд бүртгүүлсэн хүмүүс орно.

ЭРҮҮЛ МЭНД

Нялхсын нас баралт (1 хүртэл насны 1000 хүүхдэд ногдох)- ыг тухайн үед 1 хүртэлх насны нас барсан хүүхдийн тоог тухайн үед амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тодорхойлдог.

ГЭМТ ХЭРЭГ

18 ба түүнээс дээш насны 10000 хүнд ногдох бүртгэгдсэн гэмт хэргийн тоог гаргахдаа нийт бүртгэгдсэн гэмт хэргийн тоог жилийн дундаж 18 ба

түүнээс дээш насны хүн амд харьцуулан тооцно.

ХАА-Н САЛБАР

Аймгийн ИТХ-ын 2002 оны ээлжит 8-р хуралдаанаар баталсан бүсүүд:

Баруун бүс : Завхан, Наранбулаг, Өлгий, Өмнөговь, Тариалан, Ховд

Хойт бүс : Бөхмөрөн, Давст, Сагил, Түргэн

Зүүн бүс : Зүүнговь, Малчин, Тэс, Хяргас

Өмнөт бүс : Баруунтуруун, Зүүнхангай, Өндөрхангай, Цагаанхайрхан

Төвийн бүс: Улаангом хот

ТЭМДЭГЛЭГЭЭНИЙ ТАЙЛБАР :

1. Саруудыг ром тоогоор тэмдэглэв. (I, II, III, IV, V..... г.м)
I-XII жилийн эхний тухайн сарыг оруулсан өсөн нэмэгдэх дүнг харуулав.

2. Дараахь тэмдэглэлүүдийг ашиглав :

... мэдээлэл байхгүй
0.0 маш бага тоо
- гүйцэтгэл байхгүй
Д - дахин

3. Орон дэвшүүлэлтээс хамаарч зарим үзүүлэлтийн нийлбэр нь дүнтэйгээ, бүтцийг хувиар илэрхийлэхэд 100 хувиас бага зэрэг зөрөх тохиолдол байж болно.

ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО

Улсын төвлөрсөн төсвийн шилжүүлэг, дэмжлэгийг оруулан тооцсоноор оны эхний 5 сард аймгийн төсөвт 2513.7 сая төгрөгийн орлого орж төлөвлөгөөг 104.1 хувиар биелүүллээ.

Улсын төсвийн шилжүүлэг, дэмжлэгийг оруулалгүйгээр аймаг өөрөө 2062.2 сая төгрөгийн орлого бүрдүүлэхээс 2469.0 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж төлөвлөгөөг 406.8 сая төгрөгөөр буюу 19.7 хувиар давуулан биелүүллээ.

Үүнээс улсын төвлөрсөн төсөвт 1391.7 сая төгрөгийг татвар, орлогын хэлбэрээр төвлөрүүлэхээс 1630.7 сая төгрөгийг төвлөрүүлж төлөвлөгөөг 17.2 хувиар буюу 239.0 сая төгрөгөөр давууллаа. Аймгийн төсөвт 838.3 сая төгрөгийн орлого төвлөрүүлж төлөвлөгөөг 125.0 хувиар биелүүлж 167.8 сая төгрөгөөр давуулсан байна.


Ноднингийн мөн үетэй харьцуулахад аймагт төвлөрүүлэх төсвийн орлого 50.2 хувиар буюу 825.6 сая төгрөгөөр илүү, үүнээс аймагт төвлөрүүлсэн орлого 2.1 хувиар буюу 17.6 сая төгрөгөөр, улсын төвлөрсөн төсөвт төвлөрүүлэх орлого 98.2 хувиар буюу 808.0 сая төгрөгөөр илүү байна.

2010 оны эхний 5 сард улсын төвлөрсөн төсөвт төвлөрүүлэх орлогууд нэр төрлөөрөө 3.4 хувиас 5.6 дахин давж биелэгдсэн байна.



Оны эхний 5 сард аймагт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөөнөөс орлого тодорхойлох боломжгүй иргэний орлогын төлөвлөгөө 8.8, хувиараа аж ахуй эрхлэгчдийн орлого 6.7, үл хөдлөх хөрөнгө, бууны татвар 29.8, түгээмэл тархацтай ашигт малтмал, бусад нөөц ашигласны төлбөр 69.0, хүү торгуулийн орлого 55.2 хувиар тус тус тасарч байна.

Өнгөрсөн оны мөн үеэс хувиараа аж ахуй эрхлэгч иргэний орлого 60.7, цалингийн ашиг 1.6, авто өөрөө явагч хэрэгслэлийн татвар 22.4, улсын тэмдэгтийн хураамж 21.1, ашигт малтмалын нөөцийн төлбөр 45.2, рашаан ус ашигласны төлбөр 33.3, хүү торгуулийн орлого 64.9 хувиар тус тус бага байна.

Төсвийн орлогын өсөлт, бууралт, онуудаар



Аймгийн төсвийн орлогын 66.7 хувийг тусламжийн орлогоор, 23.5 хувийг орлогын албан татвараар, 2.1 хувийг тусгай зориулалтын орлогын албан татвараар, 0.8 хувийг өмчийн албан татвараар, 4.9 хувийг бусад албан татвараар, 2.0 хувийг татварын бус орлогоор тус тус бүрдүүлсэн байна.



Ноднингийн мөн үетэй харьцуулахад тусламжийн орлогын эзлэх хувь 1.8 пунктээ нэмэгдэж, орлогын албан татварын эзлэх хувь 2.5 пунктээр буурсан байна.

Аймгийн төсвийн зарлагад орлогын эзлэх хувь 23.3 хувь болсон нь сүүлийн 5 жилийн дунджаас 8.5 пунктээр илүү байна.



2005 оны эхний 5 сарыг суурь болгон авч жил бүрийн эхний 5 сартай харьцуулахад аймаг өөрөө бүрдүүлсэн төсвийн орлого сүүлийн 2 жилд 2005 оны мөн үеэс 3.3 – 5.0 дахин өсч, энэ хугацаанд төсвийн зарлага 3.1 – 3.3 дахин өссөн байна.

Төсвийн орлого, зарлагын өсөлт, 2005 I-V = 100 %


	2005 I-V	2006 I-V	2007 I-V	2008 I-V	2009 I-V	2010 I-V
Орлого	100.0	99.4	160.4	216.1	331.1	497.5
Зарлага	100.0	117.3	172.5	283.1	318.9	334.8

ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГА

Орон нутгийн төсвийн болон улсын төсвийн байгууллагуудын дүнгээр 10.6 тэрбум төгрөгийг урсгал зардалд зарцуулсан нь өнгөрсөн оны мөн үеэс 5.0 хувиар илүү байна.

Нийт зарлагын 58.1 хувийг цалин хөлсөнд, 6.0 хувийг эрүүл мэнд, нийгмийн даатгалын шимтгэлд, 29.5 хувийг бусад зардалд, 5.9 хувийг урсгал шилжүүлэгт, 0.7 хувийг хөрөнгө оруулалтанд зориулан зарцууллаа.

2010 оны эхний 5 сар, хувиар



Өнгөрсөн оны мөн үеэс цалингийн зардлын эзлэх хувь 1.0 пунктээр, хөрөнгө оруулалтын зардлын эзлэх хувь 0.9 пунктээр буурч, НДШ-ийн зардлын эзлэх хувь 0.3, пунктээр, бусад зардлын болон урсгал шилжүүлэгийн эзлэх хувь 0.6 – 0.9 пунктээр өссөн байна.

Төсвийн зардлын 19.6 хувийг төрийн үйлчилгээ, нийгмийн хэв журам, аюулгүй байдлын үйл ажиллагаанд, 54.4 хувийг боловсрол, 20.3 хувийг эрүүл мэндийн салбарт, 0.9 хувийг нийгмийн даатгал, халамжийн үйл ажиллагаанд, 0.6 хувийг ХАА-н салбарт, 2.0 хувийг ус цаг уур, байгаль орчны үйл ажиллагаанд зориулан зарцууллаа.

Ноднингийн мөн үетэй харьцуулахад төрийн үйлчилгээний салбарт зориулсан зардын эзлэх хувь 0.2 пунктээр, эрүүл мэндийн салбарынх 0.1 пунктээр, боловсролын салбарынх 0.2 пунктээр тус тус буурсан байна.

Төсөвт 178 байгууллагуудад 4.3 мянган хүн ажиллаж, ажиллагсадын тоо өнгөрсөн оны мөн үеийнхээс 1.3 хувиар өссөн байна.



ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГУУДЫН ӨГЛӨГ, АВЛАГА

Аймгийн төсөв 2010 оны 5 дугаар сард 494.2 сая төгрөгийн өртэй, 74.3 сая төгрөгийн авлагатай, өнгөрсөн оны мөн үеэс өглөг 444.2 сая төгрөгөөр буюу 10 дахин, авлага 2.2 сая төгрөгөөр буюу 3.1 хувиар өссөн байна.

5 дугаар сард 132.5 сая төгрөгийн өр шинээр үүсч, сарын эцэст 49.0 сая төгрөгийн цалингийн, 8.9 сая төгрөгийн эрүүл мэнд, НДШ –ийн, 17.0 сая төгрөгийн гэрэл, цахилгааны, 292.0 сая төгрөгийн түлш. халаалтын, 65.4 сая төгрөгийн цэвэр, бохир усны, 21.4 сая төгрөгийн тээвэр шатахууны, 1.0 сая төгрөгийн шуудан холбооны, 3.7 сая төгрөгийн томилолтын, 1.1 сая төгрөгийн хоолны, 15.7 сая төгрөгийн эмийн, 6.5 сая төгрөгийн байрны түрээсийн, 2.0 сая төгрөгийн урсгал засварын, 10.7 сая төгрөгийн бусад зардлын өртэй гарсан байна.



2010 оны 5 дугаар сарын эцэст байгаа өглөг, авлагын хэмжээг сүүлийн 4 жилийн дундажтай харьцуулахад өглөг 12.8 дахин буюу 455.9 сая төгрөгөөр, авлага 2.2 дахин буюу 40.6 сая төгрөгөөр өссөн байна



Хэрэглээний үнийн индекс

Сар бүрийн 15-21 ний байдлаар хүн амын өргөн хэрэглээний 12 бүлэг, сагсны 194 нэрийн барааны үнийн өөрчлөлтийг судалж сарын инфляци тооцож байдаг. Энэ оны 5 -р сарын 15-21 нд судлагдаж буй өргөн хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ тариф 2009 оны 12 сараас буюу оны эцсээс 8.8, 2005 оны 12 сар буюу суурь оноос 83.9, 2009 оны 5 сар буюу өнгөрсөн оны мөн үеэс 12.4, өмнөх 4-р сараасаа 2.0 хувиар өссөн байна.

Өмнөх 4-р сараас хүнсний барааны бүлгийн үнэ 1.2, тамхины дэд бүлгийн үнэ 0.7, орон сууц, ус,



цахилгаан түлшний бүлгийн үнэ 12.8, хувцас бөс барааны бүлгийн үнэ 3.7, холбооны хэрэгсэл шуудангийн үйлчилгээний бүлгийн үнэ 1.7, хоолны үйлчилгээний үнэ 6.4 хувиар өсч, гэр ахуйн барааны бүлгийн үнэ 0.9, эм тарианы бүлгийн үнэ 13, тээврийн бүлгийн үнэ 0.7, амралт чөлөөт цаг соёлын бараа үйлчилгээний үнэ 0.4, бусад бараа үйлчилгээний бүлгийн үнэ 1.1 хувиар буурч боловсролын үйлчилгээний бүлгийн үнэ тогтвортой байлаа.

Хүнсний барааны бүлэг дотроос талх гурил будааны дэд бүлгийн үнэ 0.9, сүү сүүн бүтээгдэхүүний дэд бүлгийн үнэ 10.2 хувиар буурч, хүнсний ногооны дэд бүлгийн үнэ 12.5 хувь, мах махан бүтээгдэхүүний дэд бүлгийн үнэ 19.8, төрөл бүрийн өөх тосны дэд бүлгийн үнэ 9.5, жимс жимсгэний дэд бүлгийн үнэ 1.3, саахар, жимсний чанамал, зөгийн бал, чихэр шокаладны дэд бүлгийн үнэ 1.0 хувь тус тус өссөн байна.

Гол нэрийн барааны өсөлт,

бууралтын хувь	ӨОМҮГ-сараас	
	өмнөх сараас	ӨОМҮГ-с
гурил 1-р зэрэг	-13	-22
хонины мах	13	29
үхрийн мах	29	61
хиам	13	13
сүү	-12	50
тараг	-7	40
ургамлын тос	-4	-20
өөхөн тос	20	0
мандарин	20	50
лууван	25	67
байцаа	50	0
сонгино	0	33
элсэн чихэр	0	38
зөөлөн чихэр	9	9
ундаа 1.5 л	9	20

	2010.05/	2010.05/	2010.05/	2010.05/
	2005.12	2009.05	2009.12	2010.04
ӨРӨННИЙ ИНДЕКС	183.9	112.4	108.8	102.0



1-р сард 2.1 хувийн, 2-р сард 3.7 хувийн, 3-р сард 2.2 хувийн, 5 сард 2.0 хувийн инфляцитай байв. 4-р сард үнэ тариф өмнөх сараасаа 1.6 хувиар буурсан байлаа.



Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулснаар барааны бүлгүүдээр үнийн өөрчлөлтийг тооцож үзвэл :

Хүнсний бараа, ундаа ус 12.1 %	Хүнсний бараа, ундаа усны бүлгийн үнэ 12.1 хувь өссөн нь сүү сүүн бүтээгдэхүүний дэд бүлгийн үнэ 41.2 %, мах махан бүтээгдэхүүний дэд бүлгийн үнэ 32.4 %, жимс, жимсгийн дэд бүлгийн үнэ 4.5, хүнсний ногооны дэд бүлгийн үнэ 18.4 хувь, савхарын дэд бүлгийн үнэ 14.2, хүнсний бусад бүтээгдэхүүний дэд бүлгийн үнэ 7.1, согтууруулах бус ундааны дэд бүлгийн үнэ 13.9 хувь өссөнтэй холбоотой байна
Согтууруулах ундаа, тамхи 2.9 %	Согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ дүнгээрээ 2.9 % өссөн нь согтууруулах ундааны дэд бүлгийн үнэ 0.4, тамхины дэд бүлгийн үнэ 9.4 % өссөнтэй холбоотой байна
Хувцас гутал бөс бараа, гутал 23.6 %	Хувцас, гутал, бөс барааны бүлгийн үнэ дүнгээрээ 23.6 хувь өссөн нь хөвөн бөс барааны бүлгийн үнэ 27.3, бүх төрлийн хувцасны дэд бүлгийн үнэ 24.8 % үүнээс эрэгтэй бэлэн хувцасны дэд бүлгийн үнэ 19.9 %, эмэгтэй бэлэн хувцасны дэд бүлгийн үнэ 18.6 %, хүүхдийн бэлэн хувцасны дэд бүлгийн үнэ 45.2, жижиг эдлэл хэрэгслийн дэд бүлгийн үнэ 30.2, гутлын дэд бүлгийн үнэ 17.5 хувь өссөнтэй холбоотой байна
Орон сууц, ус цахилгаан түлш 18.3 %	Орон сууц, түлш цахилгааны бүлгийн үнэ дүнгээрээ 18.3 хувь өссөн нь орон сууцны засвар үйлчилгээний дэд бүлгийн үнэ 22.4, усан хангамжийн дэд бүлгийн үнэ 3.3, цахилгаан болон хийн түлшний дэд бүлгийн үнэ 17.3 хувь өссөнтэй холбоотой байна
Гэр ахуйн бараа, тавилга 8.5 %	Гэр ахуйн бараа, тавилганы бүлгийн үнэ дүнгээрээ 8.5 хувь өссөн нь гэрийн тавилганы бүлгийн үнэ 16.3 %, цахилгаан барааны бүлгийн үнэ 12.1 %, гэр ахуйн шилэн эдлэл, сав сууцны барааны бүлгийн үнэ 34.1 %, өбмөл, нэмэн эдлэлийн үнэ 18.3 хувь өссөнтэй холбоотой байна
Эм тариа эмнэлгийн үйлчилгээ -12.6 %	Эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 12.6 % буурсан нь эм тарианы дэд бүлгийн үнэ 17.9 % буурсантай холбоотой байна
Тээвэр -1.2 %	Тээврийн бүлгийн үнэ дүнгээрээ 1.2 % буурсан нь хувийн тээврийн хэрэгслийн засвар, үйлчилгээний дэд бүлгийн үнэ 1.1 %, тээврийн үйлчилгээний дэд бүлгийн үнэ 4.2 хувь буурсантай холбоотой байна
Холбооны үйлчилгээ 24.3 %	Холбооны үйлчилгээний үнэ тариф 24.3 хувь өссөн нь суурин утасны хооронд ярих тариф өссөнтэй холбоотой байна
Амралт чөлөөт цаг соёлын үйлчилгээ 8.2 %	Амралт чөлөөт цаг соёлын үйлчилгээний бүлгийн үнэ 8.2 % өссөн нь дуу дүрс гэрэл зургийн мэдээллийн хэрэгслийн дэд бүлгийн үнэ 22.4 %, чөлөөт цаг соёлын үйлчилгээний дэд бүлгийн үнэ 1.5 % өссөнтэй холбоотой байна
Боловсролын үйлчилгээ 20.7 %	Боловсролын үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 20.7 % өссөн нь их дээд сургуулийн төлбөр 20.7 хувиар өссөнтэй холбоотой байна
ЗБ нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ 22.2 %	Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээний бүлгийн үнэ 22.2 % өссөн нь нийтийн хоолны үйлчилгээний дэд бүлгийн үнэ 27.4 хувь өссөнтэй холбоотой байна
Бусад бараа үйлчилгээ 3.5 %	Бусад бараа үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 3.5 % өссөн нь хувь хүнд хандсан үйлчилгээ 6.7 %, санхүүгийн үйлчилгээ 87.5 % өссөнтэй холбоотой байна

2010 оны 5 – р сарын 30-ны байдлаар Улаангом хотын хүнсний зах, дэлгүүрт худалдаалагдаж байгаа хүнсний гол нэрийн барааны үнийг дүнгээр нь өмнөх 4 дүгээр сарын дундаж үнэтэй харьцуулахад 4.0 хувь өссөн байна.

Махны дундаж үнэ : 2010 оны 5 дугаар сарын 30-ны байдлаар хонины махны үнэ 4-р сарын дундаж үнээс 26.6 хувь, үхрийн махны үнэ 25.9 хувь өсчээ.

5 - р сарын дундаж буюу 4 долоо хоногийн дунджаар 1 кг хонины мах 4588, үхрийн мах 4500, 1 л шингэн сүү 1475 төгрөгийн үнэтэй байсан байна.



Мөнгө, зээл

Монгол банкны мэдээгээр 13.2 тэрбум төгрөг зузаатгалаар авч, 57.2 тэрбум төгрөг гүйлгээнд гаргаснаас 63.3 тэрбум төгрөгийг буюу 110.7 хувийг эргүүлэн татсан байна.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад зузаатгалаар авсан мөнгө 4321.0 сая төгрөгөөр буюу 48.8 хувиар, гүйлгээнээс татсан мөнгө 2.2 тэрбум төгрөгөөр буюу 54.1 хувиар, гүйлгээнд

гаргасан мөнгө 19.8 тэрбум төгрөгөөр буюу 53.1 хувиар тус тус өссөн байна.

Зээлийн өрийн үлдэгдэл 27.3 тэрбум төгрөг, үүнээс хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл 1.4 тэрбум төгрөг болж ноднингийн мөн үеэс бүх зээлийн үлдэгдэл 2.2 тэрбум төгрөгөөр буюу 8.7 хувиар өсч, хугацаа хэтэрсэн зээл 196.0 сая төгрөгөөр буюу 12.4 хувиар буурсан байна.


1.1 тэрбум төгрөгийн найдваргүй зээл байгаа нь нийт зээлийн өрийн үлдэгдлийн 3.9 хувийг эзэлж байгаа бөгөөд өнгөрсөн оны мөн үеэс 813.4 сая төгрөгөөр буюу 4.0 дахин өссөн байна.

Иргэдийн хадгаламжийн үлдэгдэл 18.5 тэрбум төгрөг болж, өнгөрсөн оны мөн үеэс 38.2 хувиар буюу 5.1 тэрбум төгрөгөөр, оны эцсээс 16.7 хувиар буюу 3.1 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Нийт зээлийн 5.1 хувь нь хугацаа хэтэрсэн зээл байгаа бөгөөд Төрийн банкны нийт зээлийн 16.4, ХААН банк 4.9, Хас банкны 1.3, Хадгаламж банкны 29.7 хувийг хугацаа хэтэрсэн зээл тус тус эзэлж байна.



Арилжааны банкуудын нийт зээлийн үлдэгдэлд эзлэх хувь




Ажилгүйдэл

Хөдөлмөр зохицуулах албанд бүртгэлтэй, ажил идэвхтэй эрж буй 1922 ажилгүйдүүд байгаагийн 47.5 хувь нь буюу 940 эмэгтэйдүүд байна.


Насанд хүрсэн 10.0 мян хүнд 396 ажилгүйдүүд ноогдож байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 8.0 хувиар буурсан байна.

Оны эхний 5 сарын байдлаар ажилгүйдүүдийн тоо сүүлийн 4 жилийн дунджаас 11.4 хувиар өссөн байна.


Аж ахуйн нэгж, иргэдэд олгосон зээлийн үлдэгдэл сая.т.өг



хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл / сая.төг/



Ажилгүйдүүдийн тоо сүүлийн 5 жилээр




Энэ 5-р сард 45 хүн ажилгүйдүүдэд нэмж бүртгэгдэн ажилгүй байсан хүмүүсээс 103 хүн ажлын байнгын болон түр байраар хангагджээ.


5-р сард ажилгүйдүүдэд бүртгүүлэгчдийн 6.7 хувь нь орон тооны цомхтголоос, 11.1 хувь нь

байгууллага татан буугдсанаас, 4.4 хувь нь сургууль төгссөн, 2.2 хувь нь мэргэжлийн ажил олдохгүйгээс, 2.2 хувь нь цалин багатайгаас, 73.3 хувь нь бусад шалтгаанаар бүртгүүлсэн, ажилд орогчдын 25.2 хувь нь төрийн төсөвт байгууллагад, 6.8 хувь нь нөхөрлөл, компанид, 1.0 хувь нь хоршоонд, 67 хувь нь бусад газарт ажилд орсон байна.

ХХҮХ-т шинээр бүртгүүлсэн болон ажилд зуучлагдан орсон хүний тоо, жил бүрийн эхний сараар




Ажилгүйчүүдийн 2.9 хувь нь анх удаа ажил эрж байгаа бөгөөд 56.0 хувь 16-34 насны залуучууд, 18.8 хувь нь дээд, 18.9 хувь нь тусгай дунд болон мэргэжлийн анхан шатны, 59.6 хувь нь бүрэн ба бүрэн бус дунд боловсролтой, 2.8 хувь нь бага болон боловсролгүй хүмүүс эзэлж байна.



Эрүүл мэнд

Энэ оны эхний 5 сард 856 эхээс 856 хүүхэд амьд төрсөн нь өнгөрсөн оны мөн үеийнхээс төрсөн хүүхдийн тоо 158 аар буюу 15.6 хувиар цөөн байна.


Гэрийн төрөлт 22 гарсан нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 10 төрөлтөөр нэмэгдсэн байна.



Хүн амын нас баралт 243 гарч 1000 хүнд 3 ноогдох болсон нь өнгөрсөн оны мөн үеэс 11.5 хувиар, 1000 хүнд ноогдох нь 0.4 пунктээр нэмэгдсэн байна.

Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 54 гарч 1000 амьд төрөлтөнд 63.1 ноогдож өнгөрсөн оны мөн үеэс гаралт 19-өөр буюу 54.3 хувиар, 1000 амьд төрөлтөнд ноогдох нь 28.7 промилиэр нэмэгдсэн байна.


1000 амьд төрөлтөнд ноогдох 5 хүртэл насны хүүхдийн эндэгдэл сүүлийн 4 жилийн дунджаас / 36.5 / 26.6 промилиэр илүү байна.



5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл Баруунтуруун, Ховд, Хяргас, Улаангом, Өмнөговь сумдад аймгийн дунджаас 0.6 - 29.8 промилиэр бага, Завхан, Зүүнхангай, сумдад гараагүй, бусад сумдад аймгийн дунджаас 8.3 – 686.9 промилиэр их байна.

0-1 насны хүүхдийн эндэгдэл 42 гарч нялхсын эндэгдлийн түвшин 49.1 байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс гаралт 19-өөр, 1000 амьд төрөлтөнд ноогдох эндэгдэл 19.7 промилиэр нэмэгджээ.


Сүүлийн 4 жилийн дунджаас нялхсын эндэгдэл / 30.2 / 18.9 промилиэр илүү байна.



Нялхсын эндэгдлийн түвшин Хяргас, Улаангом, суманд аймгийн дунджаас бага Завхан, Өмнөговь сумдад гараагүй, бусад сумдад 6.5 – 258.6 промилиэр дээгүүр байна.


Нийт нас баралтын 23.1 хувийг эмнэлгийн нас баралт, үүний 17.9 хувийг хоног болоогүй нас баралт эзэлж байна.

Эхийн эндэгдэл 2 буюу Баруунтуруун, Улаангом сумдад гарч, осол гэмтлийн улмаас 25, хорт хавдрын улмаас 58 хүн нас баржээ.




Осол гэмтлийн өвчлөл сүүлийн 2 жилд өмнөх 2 жилийн дунджаас 2.5 дахин өслөө.


Хорт хавдрын өвчлөл 41 гарсан нь сүүлийн 3 жилийн дунджаас 22.7 хувиар бага байгаа бөгөөд харин нас баралт нь 5.4 хувиар илүү байна.



Халдварт өвчнөөр өвчлөгчдийн тоо 453 болж өнгөрсөн оны мөн үеэс 16.1 хувь буюу 87 гаралтаар буурсан байна. Хэдийгээр өнгөрсөн оны мөн үеэс наралт 87 тохиолдлоор буурсан ч сүүлийн 4 жилийн дунджаас 21.4 хувиар өссөн байна.





10000 хүн тутмаас 58 нь халдварт өвчнөөр өвчилж байгаа бөгөөд энэ үзүүлэлт Улаангом / 135.8 / суманд аймгийн дунджаас дээгүүр, бусад сумдад аймгийн дунджаас 1.7-55.7 процедимилиэр доогуур байна.




Халдварт өвчнөөр өвчлөгсдийн 11.7 хувь нь гепатит, 26.0 хувь нь БЗХӨ, 7.3 хувь нь сүрьеэгээр, 2.4 хувь нь мөөгөнцрөөр, 14.3 хувь нь бусад

халдварт өвчнөөр өвчилжээ.



Өнгөрсөн оны мөн үед бэлгийн замын халдварт өвчин 16.1 хувийг, сүрьеэ 5.2 хувийг эзэлж байсан бол эхний 5 сард БЗХӨ 26.0 хувь, сүрьеэ 7.3 хувийг эзлэх болсон байна. Мөн өнгөрсөн оны мөн үед гараагүй байсан гахайн хавдар өвчний гаралт 173 тохиолдлоор нэмэгдэж нийт халдварт өвчний 38.2 хувийг эзэлж байна.

Өнгөрсөн оны мөн үеэс сүрьеэ 5, хүйтэн 23, трихоманиаз 15, гахайн хавдар 173 гаралтаар нэмэгдэж, гепатит 53, хамуу 94, тэмбүү 7, бруцеллээ 3, мөөгөнцөр 11, салхинцэцэг 137, цусан суулга 1 гаралтаар буурсан байна. Түүнчлэн өнгөрсөн оны мөн үед гараагүй байсан суулгалт халдвар, гар хөл амны өвчин 1-2 тохиолдол гарсан байна.



Амбулаториор 149.3 мянган хүнд үзлэг хийгдэж, 9.1 мянган хүн хэвтэн эмчлэгдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс амбулаториор үйлчлүүлэгсдийн тоо 8.3-аар бага, хэвтэн эмчлүүлэгчид 0.4 мянгаар илүү байна.

Хувийн хэвшлийн 10 эмнэлгээр 1.9 мянган хүн үзлэг, эмчилгээ, оношлогоо хийлгэж 13.9 сая төгрөгийн орлоготой ажилласныг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал үйлчлүүлсэн хүн 1.6 мянгаар, орлого нь 5.1 сая төгрөгөөр бага байна.


ХӨДӨӨ АЖ АХУЙ

Том малын зүй бусын хорогдол


Оны эхний малын 21.1 хувь буюу 490.0 мянган толгой мал хорогдсон нь өнгөрсөн оны мөн үеэс 3.1 дахин буюу 329.7 мянган толгойгоор илүү байна.

Нийт хорогдлын 3.3 хувийг өвчний хорогдол эзэлж байна. 131.7 мянган хээлтэгч мал хорогдсон нь том малын зүй бус хорогдлын 26.9 хувийг эзэлж байна.

Нийт хорогдлын 49.5 хувийг хонь, 44.4 хувийг ямаа, 3.8 хувийг үхэр, 2.2 хувийг адуу, 0.1 хувийг тэмээний хорогдол эзэлж байна.



Том малын хорогдол, толгой, сүүлийн 4 жилээр



Түргэн, Наранбулаг, Өндөрхангай, Завхан, Өлгий, Тариалан, Өмнөговь, Зүүнхангай, Баруунтуруун, Зүүнговь сумдын оны эхний малын 21.8 – 51.9 хувь нь хорогдож аймгийн дунджаас 0.7 – 30.8 пунктээр их, бусад сумдын оны эхний малын 6.0 – 20.5 хувь хорогдсон нь аймгийн дунджаас 0.6 – 15.1 пунктээр бага байна.

Зүүнговь сумын оны эхний малын 51.9 хувь, Баруунтуруун сумын 49.2 хувь, Зүүнхангай сумын 36.5 хувь, Өмнөговь сумын 30.9 хувь, Өлгий сумын 26.1 хувь, Тариалан сумын 25.1 хувь хорогдсон нь хамгийн өндөр хорогдолтой сумдын тоонд орж байна.

Манай аймагт 1960 оны зуданд оны эхний малын 11.5 хувь буюу 162.2 мянган толгой мал, 1966 онд оны эхний малын 17.2 хувь буюу 274.1 мянган мал, 2000 онд оны эхний малын 15.2

хувь буюу 286.8 мянган мал тус тус хорогдож байсан байна.




Төллөлт, төл бойжилт

Оны эхний эхийн 56.7 хувь буюу 610.9 мянган эх мал төллөж, гарсан төлийн 58.7 хувь буюу 358.8 мянган төл бойжиж байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад бойжилтын хувь 21.4 пунктээр, төллөлтийн хувь 16.7 пунктээр тус тус бага, харин төлийн хорогдол 84.9 мянгаар өссөн байна.

Завхан, Өлгий, Улаангом, Түргэн, Өндөрхангай, Баруунтуруун, Зүүнговь, Зүүнговь, Наранбулаг, Өмнөговь, Цагаанхайрхан, Тариалан сумдын төллөх насны эхийн 10.3 – 54.4 хувь нь төллөсөн нь аймгийн дунджаас 2.3 – 46.4 пунктээр бага байна.

Нийт 252.9 мянган төл хорогдсоны 98.6 хувийг хурга, ишигний хорогдол эзэлж байна. Малчин, Ховд, Хяргас, Бөхмөрөн, Наранбулаг, Өлгий, Өндөрхангай, Баруунтуруун Зүүнговь, Зүүнхангай сумдууд төлийн хорогдол ихтэй, гарсан төлийн 23.0 – 56.1 хувийг бойжуулж байгаа нь аймгийн дунджаас 2.6 – 35.7 пунктээр бага байна.

Сүүлийн 3 жилийн дунджаас төллөсөн эх 24.1 хувиар, бойжиж буй төл 47.7 хувиар бага байна.



Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний дундаж үнэ

2009 оны 9 дүгээр сараас эхлэн хөдөө аж ахуйн гол нэрийн бүтээгдэхүүн болох 119 нэрийн бүтээгдэхүүний үнийг бүх сумдаас цуглуулан авч аймгийн дундаж үнэ тооцож байна. Бүтээгдэхүүний нэр, төрлийг нилээд задалж ангилсан учир өнгөрсөн жилүүдтэй харьцуулах боломжгүй тул өмнөх сартай харьцуулж танилцууллаа.

Малын үнэ 2010 оны 5-р сарын 28-ны байдлаар аймагт нас гүйцсэн ат ба ингэ, өсвөр насны тэмээ 234.6 – 450.0 мянга, өсвөр болон нас гүйцсэн адуу 196.2 – 350.0 мянга, өсвөр насны болон нас гүйцсэн эм ба эр үхэр 202.9 – 316.0 мянга, хуц, өсвөр насны төлөг, нас гүйцсэн эр ба эм хонь 28.3 – 65.0 мянга, ухна, өсвөр насны борлон, нас гүйцсэн эр ба эм ямаа, ухна 20.1 –

57.5 мянган төгрөгний дундаж үнэтэй байна.

Аймгийн дунджаас Улаангом, Ховд, Тариалан суманд буур, нас гүйцсэн тэмээ 50.0 – 100.0 мянга, Наранбулаг, Сагил, Улаангом суманд нас гүйцсэн морь, өсвөр насны морь, гүүний үнэ 34.0 – 53.8 мянга, Тариалан, Сагил, Наранбулаг суманд эр үхрийн үнэ 26.7 – 84.0 мянга, Сагил, Улаангом, Давст, Завхан, Малчин, Түргэн, Зүүнговь гүйцсэн эр хонины үнэ 0.8 – 20.8 мянга, Баруунтуруун, Давст, Малчин, Наранбулаг, Өндөрхангай, Түргэн суманд нас гүйцсэн эр ба эм ямааны үнэ 1.3 – 22.3 мянган төгрөгөөр тус тус илүү ханштай байна.

5 дугаар сарын 28 - ны байдлаар атан тэмээ, эр ба эм үхэр, хуц, эр ба эм хонь, ухна, эр ба эм ямааны үнэ өмнөх сартай харьцуулахад 4.5 – 73.3 мянган төгрөгөөр өсч, морь, ингэ, гүүний үнэ 5.0 – 25.0 мянган төгрөгөөр тус тус буурчээ.

ХАА - н зарим бүтээгдэхүүн:

Гол нэрийн бүтээгдэхүүн болох ноолуур 48000 , тэмээний шир 6000 , адууны шир 7000, хонины арьс 3000, ямааны арьс 500, хонь ба үхрийн мах 4500, тэмээний мах 2600, сүү 900, тэмээний ноос 2000 төгрөгийн дундаж үнэтэй байна.


Мал, амьтны гаралтай зарим түүхий эдийн үнийг өмнөх сартай харьцуулахад ноолуур 250 төгрөг, хонины арьс 2500 төгрөгөөр өсч, харин ямааны арьсны үнэ 8500 төгрөг, тэмээний шир 4000 төгрөг, тэмээний ноос 500 төгрөг, тэмээний мах 200 төгрөгөөр тус тус буурч, хонь, үхрийн махны үнэ 875 - 925 төгрөгөөр өссөн байна.

Газар тариалан болон бусад бүтээгдэхүүн :

Улаан буудай 525.0 мянга, сонгино 2000, түлээний мод 23500 төгрөгийн дундаж үнэтэй байна.

Өмнөх сартай харьцуулахад улаан буудай 25.0 мянган төгрөгөөр

буурч, түлээний мод 1188 төгрөгөөр өсчээ.





Үр тариа, төмс, хүнсний ногоо тариалалт

4063.5 га-д үр тариа, үүнээс 3837.5 га-д улаан буудай, 175.3 г-д төмс, 124.9 га-д хүнсний ногоо, 162.3 га-д тэжээлийн ургамал нийт 4.5 мянган га-д тариалалт хийлээ.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад үр тариа 1985.5 га, төмс 18.9 га, хүнсний ногоо 7.9 га, тэжээлийн ургамал 94.3 га-аар тус тус өсчээ. Баруунтуруун сум 3200 га, Тариалан сум 388 га, Сагил сум 310 га-д үр тариа тариалсан нь аймгийн нийт тариалсан үр тарианы 95.9 хувийг эзэлж байна.

Баруунтуруун, Улаангом сумдад 218.0 га-д төмс, хүнсний ногоо тариалсан нь төмс, хүнсний ногоо тариалалтын 72.6 хувийг эзэлж байна.

Хаврын тариалалтанд 431.9 тн үрийн буудай, 240.3 тн төмсний үр, 0.9 тн хүнсний ногооны үр хэрэглэсэн байна.




АЖ ҮЙЛДВЭР

Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэл 2005 оны зэрэгцүүлэх үнээр 1.8 тэрбум төгрөг болж өнгөрсөн оны мөн үеийнхээс 16.1 хувиар буюу 249.0 сая төгрөгөөр өслөө.



Нийт үйлдвэрлэлтийн 58.6 хувийг хүнс ундааны үйлдвэрлэл, 26.1 хувийг эрчим хүч түгээлт, 8.3 хувийг нүүрс олборлолт, 4.8 хувийг бусад боловсруулах үйлдвэрлэл, 1.3 хувийг усан хангамж, 0.8 хувийг хувцас үйлдвэрлэл эзэлж байна.

Аж үйлдвэрийн салбарын бүтэц хувиар, 2010 оны 05 сар



Өнгөрсөн оны мөн үеэс /зэрэгцүүлэх үнээр тооцсоноор/ нүүрс олборлолт 59.4, эрчим хүч түгээлт 20.6, хүнс ундааны үйлдвэрлэл 10.5, хувцас үйлдвэрлэл 92.7 хувиар өсч, бусад боловсруулах үйлдвэрлэл /өлөн, шево, булигар, хөх шир / 8.5, усан хангамж 1.6 хувиар тус тус буурсан байна.

Оны үнээр 2.8 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж 3.3 тэрбум

төгрөгийн борлуулалтын орлоготой ажилласан нь өнгөрсөн оны мөн үеэс борлуулалтын орлого 25.1 хувиар өслөө. Нийт борлуулалтын 3.4 хувь буюу 114.0 сая төгрөгийн боловсруулсан өлөн гэдэс болон олборлосон нүүрс гадаадад экспортолсон байна.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад аж үйлдвэрийн салбарт эзлэх хувцас үйлдвэрлэл 0.2, усан хангамж 1.0, нүүрс олборлолт 1.3 эрчим хүч түгээлт 3.8 пунктээр өсч, хүнс ундааны үйлдвэрлэлтийн хувь 4.5, бусад боловсруулах үйлдвэрлэл 1.0 пунктээр буурлаа.



Салбарын бүтэц

	2008 I-Y	2009 I-Y	2010 I-Y
Цахилгаан дулаан түгээлт	27.8	22.3	26.1
Нүүрс олборлолт	9.2	7.0	8.3
Бусад ашигт малтмал олборлолт	0	0	0
Хүнс ундаа үйлдвэрлэл	56.6	63.1	58.6
Хувцас үйлдвэрлэл	0.3	0.6	0.8
Мод модон бүт үйлдвэрлэл	0	0	0
бусад боловсруулах аж үйлдвэр	4.7	5.8	4.8
Усан хангамж	1.4	1.2	1.3
Дүн	100.0	100.0	100.0


2005 оны зэрэгцүүлэх үнээр тооцсоноор суурь он буюу 2005 оноос боловсруулах үйлдвэрлэл 3д, уул уурхай олборлолтын салбар 2.4д, эрчим хүч, усан хангамжийн үйлдвэрлэл 36.0 хувиар өссөн байна.



Аж үйлдвэрийн салбарын зарим нэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлтийг 2005 оны мөн үетэй харьцуулбал өлөн 2.7, архи 3.4 ундаа 5.3, нарийн боов 2.2, нүүрс 2.5 дахин, дулаан 49.5 хувиар өсч, түгээсэн цэвэр ус 0.6, ундаа 9.6 хувиар буурсан байна.



2005 оноос импортын цахилгаан 51.8, цахилгааны хэрэглээ 49.0 хувиар өссөн байна.






Аж үйлдвэрийн чиглэлийн аж ахуйн нэгжүүд 30 нэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн байна.

Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний гол нэр төрлийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 19 нэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлтэнд өсөлт гарч 8 нэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл буурч, өнгөрсөн оны түвшинд 2 нэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгдсэн байна.

Гол нэрийн бүтээгдэхүүнээс хүнсний давс 7.4, варень 5.0, сироп 3.6, дахин, гутал 96.9, нүүрс 59.4, эмэгтэй хослол 55.6, хэрчсэн гурил 33.0, хөх шир 25.0, дулаан 20.6, чацарганы тос 20.1, хиам 15.8, нарийн боов 15.7, талх 15.7, дээл 10.5, архи 8.6 хувиар өсч, чацарганы шүүс 72.2, түгээсэн цэвэр ус 1.6, гэрийн бүрээс 28.6, ундаа 51.1, витамин жүүс 50.0, өлөн 9.6, шевро 28.6, булигар 45.5 хувиар тус тус буурсан байна.


		2006 I-Y	2007 I-Y	2008 I-Y	2009 I-Y	2010 I-Y
нүүрс	тн	12.6	12.3	18.6	15.5	24.7
архи	мян л	144.7	283.3	179	216	234.6
ундаа	мян л	69.4	27.1	26.7	57.7	28.2
нарийн боов	тн	33.9	131.9	88	74.6	86.3
өлөн	мян гог	20	31.5	67.8	69.5	82.8



Барилга

Барилгын гүйцэтгэгч 5 аж ахуйн нэгжүүд 760.7 тэрбум төгрөгийн БУИЗ-ын ажил гүйцэтгэсэн нь өнгөрсөн оны мөн үеэс оны үнээр 45.1 хувиар, инфляциар засварласнаар 60.2 хувиар буурсан байна.

Нийт барилга угсралт их засварын ажлын 83.1 хувь нь буюу 632.3 сая төгрөгийн ажлыг барилга объект, 16.9 хувь нь буюу 128.4 сая төгрөгийн ажлыг инженерийн барилга /шугам сүлжээ, худаг/ байгууламжинд хийгдсэн байна.



Аривжих Увс ХХК Түргэн сумын хүн эмнэлгийн барилгад 60.0 сая төгрөгийн, тэс сумын дотуур байрны барилгад 60.0 сая, цэргийн ангийн гал зуухны барилгад 190.0 сая төгрөгийн, Ундрага констракшин ХХК 16 айлын орон сууцны объект, 168.0 сая төгрөг, Амарсанаа ХХК Өндөрхангай сумын соёлын төвийн барилгад 82.2, хүн эмнэлгийн барилгад 72.0, Сан тех Увс ХХК зүүн тойргийн бохир усны шугамын угсралт, орон сууцны хорооллын дулаан цэвэр усны шугаманд 100.0 сая төгрөгийн барилга угсралтын ажил хийгээд байна. Ус эрдэнэ ХХК Өмнөговь суманд 10.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй худаг, Наранбулаг суманд 18.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй худаг барьж байгуулсан байна

Гэмт хэрэг

Оны эхний 5 сард бүртгэгдсэн гэмт хэргийн тоо 169 болж өнгөрсөн оны мөн үеэс 7.0 хувиар, сүүлийн 4 жилийн дунджаас 2.4 хувиар тус тус өсч, гэмт хэрэгт холбогдогч 178 болж өнгөрсөн оны мөн үеэс 9.9 хувиар өссөн байна.



Гэмт хэрэгт холбогдогчдоос 3.9 хувь буюу 7 эмэгтэй, мөн 2.8 хувь буюу 5 хүүхэд байгаа бөгөөд өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад хэрэгт холбогдогч эмэгтэйчүүдийн тоо 30.0 хувиар, хүүхдүүдийн тоо 16.7 хувиар тус тус буурсан байна.

Гэмт хэргийн улмаас иргэд байгууллагад 172.3 сая төгрөгийн хохирол учраад байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 31.3 хувиар багассан байна. Нийт үйлдэгдсэн гэмт хэргийн 14.7 хувь нь бүлэглэж үйлдсэн, 28.4 хувь нь согтуугаар үйлдэгдсэн бөгөөд өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад бүлэглэсэн хэрэг 8.0 пунктээр буурч, харин согтуугаар үйлдсэн хэрэг 5.0 пунктээр буюу гаралтын тоо 29.7 хувиар өссөн байна.

Гэмт хэргийн өнгөөр авч үзвэл өнгөрсөн оны мөн үеэс хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг 9.3 хувиар, үүний дотроос иргэдийн эрх чөлөө, эрүүл мэндийн эсрэг хэрэг 4.4 хувиар, бусдыг амиа хорлоход хүргэх гэмт хэрэг 50.0 хувиар тус тус буурсан байна.


Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 10.7 хувиар, үүний дотроос нийт хулгайн гэмт хэрэг 18.6 хувиар буурсны дотор иргэдийн өмчийн хулгайн хэрэг 33.3 хувиар, малын хулгай 29.7 хувиар, завших, үрэгдүүлэх гэмт хэрэг 71.4 хувиар тус тус буурсан бөгөөд бусад хулгайн гэмт хэрэг 8 дахин, бусад өмчлөх эрхийн гэмт хэрэг 2 дахин тус тус өссөн байна.

Үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг 8 дахин, хүүхэд гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг хэрэг 50 хувиар, тээврийн хэрэгсэлийн ХАБ, ашиглалтын журмын эсрэг хэрэг 50 хувь, нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг 76.9 хувиар, захиргааны журмын эсрэг гэмт хэрэг 6 дахин тус тус өссөн бөгөөд өнгөрсөн оны 5 сард гарч байгаагүй хүнийг санаатай алах гэмт хэрэг, булаалтын гэмт хэрэг 1-2 тохиолдол гарсан байна.



Нийт гэмт хэргийн 51.5 хувь нь Улаангом суманд үйлдэгдсэн ба үйлдэгдсэн нийт хэргийн дийлэнх хувийг / 28.4 / нь өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг эзэлж байна.

Шүүхээр 63 гэмт хэрэгт 91 хүн ял шийтгүүлсэн нь өнгөрсөн оны мөн үеэс шийтгүүлсэн гэмт хэрэг 32.3 хувиар, шийтгүүлсэн хүний тоо 46.5 хувиар тус тус буурсан байна.



ЦАГ УУРЫН БАЙДАЛ

2010 оны 5-р сард агаарын дундаж температур Улаангом, Завхан, Давст, Ховд, Наранбулаг сумдад 10.2--ээс 12.9 хэм дулаан, хөрсний дундаж температур

Завхан, Зүүнговь, Ховд, Өлгий, Наранбулаг сумдад 17.8 ээс 21.2 хэм дулаан байлаа.

10 м/сек –ээс их салхитай өдөр Баруунтуруун, Зүүнговь сумдад 21, Зүүнхангайд 24, Наранбулагт 18 хоног байв.

Баруунтуруунд 12, Малчинд 10, Улаангомд 10, Тэсд 11 хоног тундастай байж нийлбэрээрээ Баруунтуруунд 26.0 мм, Зүүнговьд 22.8 мм, Түргэнд 37.2 мм тундас орсон нь аймгийн хэмжээнд хамгийн их тундастай сумдууд болж байна.

Ургамлын дундаж өндөр Өмнөговь 7 см, Зүүнговь 7 см, Өлгий 6 см, Баруунтуруун, Завхан, Давст, Ховд, Хяргас, Наранбулаг, Зүүнхангай сумдад тус тус 4 см байгаа нь бусад сумдаас харьцангуй илүү байна.

АЙМГИЙН

СТАТИСТИКИЙН ХЭЛТСИЙН ДАРГА

Ж.ЭРДЭНЭСҮРЭН